

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

**ШҮҮХ НҮҮДЭЛЛЭН АЖИЛЛАХ
ТАЛААР ГАДААД УЛСЫН
ТУРШЛАГА**



ЛАВЛАГАА

АГУУЛГА

Удиртгал	2
Шүүх нүүдэллэн ажиллах талаарх гадаад улсуудын туршлага.....	2
Бангладеш улс	3
Пакистан улс.....	3
Зураг 1	4
Энэтхэг улс	4
Зураг 2	5
Конго улс	5
Зураг 3	7
Уганда улс.....	7
Зураг 4	7
Сомали улс.....	8
Зураг 5	8
Австрали	8
Дүгнэлт.....	9
Зөвлөмж	10



ШҮҮХ НҮҮДЭЛЛЭН АЖИЛЛАХ ТАЛААРХ ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА

Удиртгал

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар баталсан “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дэх хэсэгт анхан шатны шүүхийн шүүн таслах ажлыг иргэдэд ойртуулах, уналгын болон тусгай зориулалтын авто машинаар хангах, шүүх нүүдэллэн ажиллах талаар дурдсан байна.

Мөн 2012 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт “Шүүх, шүүгч нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулахад шаардагдах байнгын болон нүүдэллэн ажиллах байр, иргэдийг хүлээн авах болон шүүх хуралдааны танхим, тээвэр, холбоо, мэдээллийн болон тусгай зориулалтын техник хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж, хамгаалалтаар хангагдсан байх бөгөөд тэдгээрийн стандарт, нөхцлийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно” гэж, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт “Анхан шатны шүүх нь шүүн таслах ажиллагааг иргэдэд ойртуулах зорилгоор нүүдэллэн ажиллаж болох бөгөөд ийнхүү ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална” гэж тус тус заасны дагуу Шүүх нүүдэллэн ажиллаж болох нөхцөл, шаардлага, шүүн таслах ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг хангахад төрийн байгууллага, албан тушаалтнаас үзүүлэх дэмжлэг, төсөв, зардал болон бусад анхаарал хандуулан ажиллах асуудлуудыг нарийвчлан тодорхойлох зорилгоор Шүүхийн судалгаа мэдээллийн төвөөс гадаадын улсын туршлагыг судлан дараах харьцуулсан судалгааг гүйцэтгэв.

Шүүх нүүдэллэн ажиллах талаарх гадаад улсуудын туршлага

Олон улсад “Mobile court” болон “Court/Justice on Wheels” хэмээн нэрлэгддэг нүүдлийн шүүхийн тогтолцоог эдүгээ Африкийн ядуу буурай, дотоодын зөрчил, мөргөлдөөн ихтэй орнууд болон Азийн хүн ам олонтой, ядуурлын түвшин өндөртэй улсуудад голдуу ашиглаж байна.

Харин өндөр хөгжилтэй улсуудад нүүдлийн шүүх нь өмнө нь тойргийн шүүх /circuit court/ маягаар үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд эдийн засгийн өндөр хөгжил, хүн амын боловсрол болон амьжиргааны түвшин дээшлэхийн хэрээр хямд шүүн таслах ажиллагаанаас татгалзаж, байнгын үйл ажиллагаа явуулдаг, өндөр мэргэшсэн шүүхээр үйлчлүүлэхийг илүүд үзэх болж өдгөө тус улсуудад нүүдлийн шүүх үйл ажиллагаа явуулахгүй байна.

Тиймээс энэхүү харьцуулсан судалгаанд Африкын Конго, Сомали, Уганда, Азийн Бангладеш, Пакистан, Энэтхэг өндөр хөгжилтэй орнуудаас Австрали улсыг тус тус сонгон судаллаа.

Бангладеш улс

2009 онд Бангладеш улс Нүүдлийн шүүхийн /Mobile court/ хуулиа баталсан бөгөөд 2009 оны 07 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд болсон бүх нийтийн эмх замбараагүй байдлаас үүдэн гарсан зөрчил, маргаан, гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд анх удаагаа хэрэглэж эхэлсэн байна¹.

Бангладеш улсын Нүүдлийн шүүхийн гол онцлог нь Засгийн газраас томилогддог гүйцэтгэх ажилтан /executive magistrate/ нүүдлийн шүүхийн үйл ажиллагааг явуулдаг² бөгөөд эрүү, иргэний бүхий л хэргийг хянан шийдвэрлэн, зохистой, мөрдөн шалгах ажлыг гүйцэтгэлгүй, хуульчийн тусламж авах боломж олголгүйгээр гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй этгээдийг 2 жил хүртэл хугацаагаар хорих, мөнгөн торгууль ногдуулах зэргээр 80 гаран төрлийн хэрэгт³ шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрхтэй байна. Тус улсын судлаачдын зүгээс эдгээр гүйцэтгэх ажилтнуудад шүүгчтэй адил шүүн таслах үйл ажиллагаа явуулах, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах өндөр эрх мэдэл олгосон явдлыг эрх мэдэл хуваарилах онолыг зөрчсөн, Эрх зүйт ёсыг хөсөрдүүлж, шүүх засаглал болон гүйцэтгэх эрх мэдлийг хольж, хутган Үндсэн хуулийг зөрчсөн үйлдэл хэмээн хурцаар шүүмжилж байгаа хэдий ч тус нүүдлийн шүүх нь ядуу буурай, нийгмийн эмзэг давхрагынханд зардал багатайгаар шуурхай хугацаанд шудрага ёсыг тогтоон өгч байгаа шилдэг хувилбар⁴ гэж үзсээр байна.

Пакистан улс

Пакистан улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн /UNDP/ 15 сая рупигийн санхүүжилтээр 11 ширхэг тусгайлан тоногдсон автобусыг төвөөс алслагдсан орон нутагт очиж, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх нүүдлийн шүүхийн зориулалтаар олгосон бөгөөд⁵ тус хөтөлбөрөөс одоогийн байдлаар нүүдлийн шүүхийн үйл ажиллагаа явуулахад зориулан 8 шүүгч, 18 хуульчийг эвлэрүүлэн зуучлагчаар сургаж⁶, 2013 оны эцэс гэхэд нийт 48 шүүгч, 72 эвлэрүүлэн зуучлагчдыг нэмж сургах төлөвлөгөөтэй байна. Нүүдлийн шүүх нь ихэвчлэн жижиг иргэний хэрэг,

¹ Md Raisul Islam "Constitutionality of mobile court during the hartal" published on the Bangladesh Human Rights Network.

² M S Sidiqi "Mobile courts and independence of judiciary" 2011.

³ Shariful Islam Selim "Mobile Court Ordinance, 2009: Consistence with law" 2013.

⁴ M S Sidiqi "Mobile courts and independence of judiciary" 2011.

⁵ Олон улсын мэдээллийн Reuters агентлагын 2013 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн мэдээлэл.

<http://www.reuters.com/article/2013/08/28/us-pakistan-mobile-courts-idUSBRE97R0QO20130828>

⁶ НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр.

http://www.undp.org/content/undp/en/home/ourwork/crisispreventionand recovery/successstories/pakistan_s-justice-on-wheels-.html

нийгмийн хор аюулын хувьд төдийлөн их биш эрүүгийн хэрэг болон өсвөр насныхан холбогдсон хэргийг хянан шийдвэрлэж, маргааныг шүүн таслаж, шүүхийн шийдвэр гаргахаас илүүтэйгээр эвлэрүүлэн зуучлагчдын оролцоотойгоор эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулж, альтернатив шийдвэр гаргахыг гол зорилт болгон ажиллаж байна. Мөн тус улсын Дээд шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашрах, хойшлуулах, хэрэг шийдвэрлэлгүй орхигдох явдлыг бууруулах зорилгоор нүүдлийн шүүхийн тоог нэмэгдүүлэн суурин болгонд байгуулах, Жирга тогтолцоотой⁷ хэрхэн уялдуулан ажиллаж талаар санаачлага гарган ажиллахаас гадна тус шүүхийн бүрэлдэхүүнд шүүгч, прокурор, эвлэрүүлэн зуучлагчдыг бүрэн хамруулж, хязгаарлагдмал бүс нутгийн иргэдэд эвлэрүүлэн зуучлах болон шүүн таслах үйл ажиллагааг хүртээмжтэй болгоход анхаарал хандуулж байна.

Зураг1



Энэтхэг улс

Энэтхэг улсад 1 сая хүнд 12 шүүгч л ноогддог тул нэг дор 10-20 сая хэрэг шүүхүүд дээр бөөгнөрч хянан шийдвэрлэхэд олон жил шаардагдаж, заримдаа 10-20 жилээр ч үргэлжлэх тохиодол гарч иргэдийн мөнгө, цагийг дэмий үрж, шүүхэд итгэх итгэлийг бууруулж, Энэтхэг улсын шүүхийн тогтолцоог ганхуулж эхэлсэн⁸.

Мөн тус улсын хүн амын дундах ядуурлын түвшин өндөр, иргэдийнх нь эрх зүйн боловсролын түвшин доогуур, өөрийн эрхээ хэрхэн хамгаалах талаар санаачлага гарган ажиллах нь бүү хэл амьдралдаа тосгоноосоо гарч үзээгүй ядуу буурай иргэдийн дунд гэмт хэрэг ихээр гарах болж гэмт хэргийн хохирогч болсон, эд зүйлсээ алдсан, хүчирхийлэлд өртсөн эдгээр иргэдийн эрхийг хамгаалах, шудрага ёсыг сахиулах үүднээс

⁷ Жирга /jirga/ тогтолцоо нь тосгоны ахмадуудаас бүрдсэн нэгдсэн зөвлөл бөгөөд тус тосгондоо хуулийн дагуу заавал биелэгдэх шинж чанаргүй ч уламжлал ёсоор хэлбэрлэлтгүй даган мөрддөг шийдвэр гаргадаг.

⁸ Amrit Dhillon "Mobile court bus visits India's rural poor" нийтлэл. Телеграф сэтгүүл, 2007.

<http://www.telegraph.co.uk/news/worldnews/1561973/Mobile-court-bus-visits-Indias-rural-poor.html>

Гватималад 2003 онд анх удаа Дугуйн дээрх шударга ёс төсөл⁹ -ийг эхлүүлж, зөвхөн өсвөр насны хүүхдийн хэргийг шийдвэрлэх чиглэлээр хэрэгжиж эхэлсэн. 2007 оны 08 дугаар сараас Нүүдлийн шүүхийн хянан шийдвэрлэх хэргийн тоо, төрлийг нэмэгдүүлэн Энэтхэг улсын хэд хэдэн мужуудад үйл ажиллагаагаа явуулахаар өргөжүүлсэн бөгөөд тус үйл ажиллагаатай холбогдуулан Энэтхэгийн Хууль зүйн сайд “Иргэд шударга ёсыг олохын тулд шүүхрүү очдог байсан бол өдгөө нүүдлийн шүүхийг бий болгосноороо шудрага ёс ард түмэнрүү очиж байна¹⁰” хэмээн цохон тэмдэглэсэн байна. Энэтхэг улсын хувьд нүүдлийн шүүх байгуулах гол үзэл баримтлал нь иргэн, эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн шүүн таслах ажиллагааг алслагдсан бүс нутгийн иргэдэд ойртуулж, тэднийг замын унаа, хоолны зардал гэх мэт нэмэлт зардлаас чөлөөлж, илүү олон хүн өөрийн эрхээ хамгаалуулж, маргаанаа шүүхээр шийдүүлэх боломж олгох явдал юм.

Энэтхэг улсын нүүдлийн шүүх нь энгийн шүүх шиг шаардлагатай бүх албан хаагчдаас бүрдэх бөгөөд тус бүр 25-30 тосгоныг хамарсан үндсэн 4 төвийг сонгон 7 хоногийн 4 өдөр 4 өөр газарт, 2 өдөр нь энгийн шүүх шиг ажиллан нэг газраас нөгөө газарт нарийн төлөвлөгөө, хуваарийн дагуу эрүү, иргэний бүх төрлийн хэргийг шүүх бүрэлдхүүнээр авч хэлэлцэн нэг өдөрт наад зах нь 60 гаран хэргийг шийдвэрлэн шүүхүүд дээр урт хугацааны турш гацаад байсан 15,6 сая хэргийг шийдвэрлэхийг чармайн ажиллаж байна¹¹.

Зураг 2



Конго улс

Конго улсын шүүхийн тогтолцоо сул байдгаас гэмт хэрэгтнүүд үйлдсэн хэрэгтээ зохих ял шийтгэл хүлээхгүй байх, оргон зайлах явдал ихээр гарах болсонтой холбогдон

⁹ Court on wheels.

¹⁰ M S Sidiqui “Mobile courts and independence of judiciary” 2011.

¹¹ Rama Lakshmi “Bus Expedites Wheels of Justice in Rural India” Вашингтон пост сэтгүүл.

<http://www.washingtonpost.com/wp-dyn/content/article/2007/08/17/AR2007081702173.html>

тус оронд гэмт хэрэг ихээр гарч, эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг зөрчих явдлаараа дэлхийн хамгийн аюултай улсаар тодроод байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд Конго улсад охид эмэгтэйчүүдийг зэвсэгт хүчин, цэрэг, цагдаагийнхан, бослого гаргагчид болон бусад этгээдүүдийн зүгээс хүчирхийлэх явдал ихээр гарч, тус хэргийг илрүүлэн, шүүн таслаж, зохих шийтгэл ногдуулах явдал шүүхийн хүртээмж, шүүгчийн хүрэлцээ, газар нутгийн байрлалаас шалтгаалан үндсэндээ орхигдож эхэлсэн байна¹².

1996 онд НҮБ-ээс хийсэн судалгаанд нийт 500,000 охид эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн гэж дурьдсан¹³ бол, 2010 оны 07 дугаар сард гэхэд л тус онд нийт 387 эмэгтэй, 2011 онд 62 эмэгтэй босогчид болон цэргүүдийн зүгээс хүчирхийлэлд өртсөн байна. Тиймээс 2009 оноос эхлэн Нээлттэй нийгэм хүрээлэнгээс Өмнөд Африкын улсуудад охид, эмэгтэйчүүдийг хамгаалах зорилгоор нүүдлийн шүүхийг /mobile gender court/ байгуулсан. Тус шүүх нь шудрага ёсыг сахиулж, хохирогчийн нэр төр, эрхийг хамгаалан орон нутгийн анхаарлыг энэхүү хүчирхийлэлийг таслан зогсооход анхаарал хандуулж, нөхцөл байдлыг өөрчлөхөд түлхэц болж өгсөн.

Нүүдлийн шүүх нь шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн багаас бүрдэн Конго улсын алслагдсан бүсүүдэд очиж, олон тооны хэргүүдийг хямд зардлаар үр дүнтэйгээр хянан шийдвэрлэн шудрага ёсыг тогтоож, хохирогчдын эрхийг хамгаалахад дорвитой үйл ажиллагаа явуулан 2009 оны 10 дугаар сараас 2012 оны 10 сар хүртэл нийт 3 жилийн хугацаанд нийт 260 шүүхийн ажилтанг сургаж, тус шүүх нь алслагдсан бүс нутгуудад нийт 20 удаагийн шүүх хурал хийж, 382 хэргийг шийдвэрлэн 204 хүчингийн хэрэгт зохих шийтгэлийг ногдуулж, 82 гэмт хэрэгтэнд шийтгэл ногдуулж, 67 хоригдолыг гэм буруугүйд тооцон суллаж, 29 хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Мөн шүүх хурлыг нээлттэй, олон нийтийн өмнө хийдэг явдал нь иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, эрх зүйт ёсыг ойлгоход ихээхэн дэмжлэг үзүүлж байна. Конго улсын нүүдлийн шүүх нь хүчингийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх зорилготой байгуулагдсан боловч тус бүс нутагт дотоодын зэвсэгт мөргөлдөөн, дайны гэмт хэрэг ихээр гардаг тул олон улсын байгууллагын зүгээс тус улсын нүүдлийн шүүхийг олон улсын эрх зүйн дагуу хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг, хүн амины хэрэг, хулгайн хэргийг шийдвэрлэх чадамжтай болгохыг чармайж байна¹⁴.

¹² Нээлттэй нийгэм хүрээлэн “Justice in DRC: Mobile Courts Combat Rape and Impunity in Eastern Congo” илтгэл. <http://www.opensocietyfoundations.org/sites/default/files/justice-drc-20130114.pdf>

¹³ Think Africa press агентлаг. Mobile Gender Courts: Delivering Justice in the DRC <http://thinkafricapress.com/drc/tackling-impunity-democratic-republic-congo-rape-gender-court-open-society>

¹⁴ Think Africa press агентлаг. Mobile Gender Courts: Delivering Justice in the DRC <http://thinkafricapress.com/drc/tackling-impunity-democratic-republic-congo-rape-gender-court-open-society>
Think Africa Press агентлаг нь Лондонд байрлаж Африкын улсуудын цаг үеийн мэдээллийг дэлхий нийтэд Англи хэл дээр мэдээллэдэг онлайн сэтгүүл.

Зураг 3



Уганда улс

Уганда улс нийт 234,150 дүрвэгчтэй¹⁵ бөгөөд хамгийн том дүрвэгчдийн лагерь 180 кв км талбайг хамран байрлах боловч тус лагерьт ямар ч шүүх байхгүйгээс гадна хамгийн ойрхон шүүхрүү очиход 50 км гаран зайтай байгаа нь шудрага ёсыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэгтнийг шийтгэх явдал удаашрах эрсдэлд хүргэж байгаа тул дүрвэгчдэд болон өөрийн иргэдэд шүүхийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн нүүдлийн шүүхийг туршилтын журмаар ажиллуулаж эхэлсэн.

НҮБ-ын дүрвэгсдийн асуудал хариуцсан байгууллага, Уганда улсын Засгийн газар болон Хүний эрхийн хороо хамтран тус туршилтын шүүхийн төслийг эхлүүлж, хуульчид сайн дураараа эл үйл ажиллагаанд оролцож, үнэ төлбөргүйгээр дүрвэгсэд болон нутгийн иргэдэд шүүхийн үйлчилгээг шуурхай хүргэхээр жил бүр наад зах нь 3 удаа нүүдлийн шүүхийг 15-30 хоногоор ажиллуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Зураг 4



¹⁵ Нэгдсэн Үндэстний байгууллагын Дүрвэгсэдийн хорооноос 2013 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр гаргасан мэдээлэл. Mobile court scheme launched in Uganda's Nakivale refugee settlement.

<http://www.unhcr.org/516d29359.html>

Сомали улс

Сомали улсад Нүүдлийн шүүх нь анх 2008 онд алслагдсан нийт 5 бүс нутагт амьдарч байгаа иргэдэд, түүн дундаа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд туслах зорилгоор НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн тусламжтайгаар байгуулагдсан¹⁶.

Хууль зүйн яамны сайдын дэмжлэгтэйгээр шүүхийн хуучин механизмыг өөрчилж, шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн зардлыг багасгах зорилгоор хуульзүйн клиник үйлчилгээг ашиглаж, Сомалийн хуульчдын холбооны хуульчид, шүүгч, прокурорууд алслагдсан бүсүүдэд очин иргэдэд шаардлагатай эрх зүйн тусламж үзүүлэх, хэрэг маргааныг газар дээр нь хянан шийдвэрлэж байна. Нүүдлийн шүүх нь тухайн орон нутагт шүүхээр шийдүүлж байгаа хэргийн тоог өсгөхөд нөлөөлж, 2008 онд байгуулагдсанаас хойш 13 нүүдлийн шүүх нь эмзэг бүлгийн иргэдийн нийт 3329 хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд хүчин, хүчирхийллийн гэмт хэргийг шийдвэрлэхэд онцгой анхаарал хандуулж ажиллаж байна¹⁷.

Зураг 5



**Ав
стр
ал
и**

А

**встр
али
улс
ын
зари
м
муж
ууда**

д шудрага ёсны төлөөлөгчийн тогтолцоо буюу Justice of Peace гэж нэрлэгдэх, омгийн ахлагч эсвэл нэр хүндтэй иргэнийг сонгон зарим онцгой эрх олгодог тогтолцоо байх бөгөөд Австралийн Күүнслэнд мужид тус тогтолцоо илүү онцлогтойгоор оршин байдаг нь мэргэшсэн шудрага ёсны төлөөлөгчийн тогтолцоо¹⁸ юм. Энэ нь тус төлөөлөгч нь шүүн таслах эрхтэйгээс гадна тухайн этгээдийн гаргасан шийдвэр нь шүүхийн шийдвэрийн

¹⁶ UNDP "Governance and Rule of Law Programme" <http://www.so.undp.org>

¹⁷ Нэгдсэн Үндэстний байгууллагын Дүрвэгсэдийн хорооноос 2013 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр гаргасан мэдээлэл. Mobile court scheme launched in Uganda's Nakivale refugee settlement. <http://www.unhcr.org/516d29359.html>

¹⁸ Justice of Peace (Magistrate) or JP Magistrate or Justice of Peace (Qualified).

нэгэн адил хүчин чадалтай. Энгийн шудрага ёсны төлөөлөгч нь баримт бичгийг гэрчлэх, тэдгээрийн хуулбарыг нотлох зэрэг манай улсын Нотариатын чиг үүрэгтэй ойролцоо чиг үүрэгтэй бол мэргэшсэн шудрага ёсны төлөөлөгч /Justice of Peace (Qualified)/ нь дээрх үүргээс гадна шүүх хурлаар хэрэг нь шийдэгдтэл тухайн хариуцагчийг саатуулах, батлан даалтанд авах, хариуцагч гэм буруугаа хүлээсэн үед нийгмийн хор аюулын хувьд бага гэмт хэргийг таслан шийдвэрлэх зэрэг шүүгчийн эдэлдэг зарим эрхийг эдэлдэг байна.

Алслагдсан бүсүүдэд үйл ажиллагаа явуулах JP Magistrate Court хөтөлбөрийг 1993 оноос эхлэн Күүнслэнд мужийн засгийн газраас Австралийн уугуул иргэд болох Абригончуудад зориулан явуулж эхэлсэн. Тус хөтөлбөр нь Абригончууд болон Торрес Стайт арлын хүмүүс гэмт хэрэгт холбогдох, хохирогч болох үеүүдэд ямар ч хамгаалалтгүй байгаа явдалд туслах үүднээс хэрэгжиж эхэлсэн. Тус уугуул иргэдэд зориулсан Эрүүгийн шүүхийн тогтолцоонд тухайн нийгэмд байгаа өндөр настнууд болон олны хүндлэл хүлээсэн хүмүүс голлон шийдвэр гаргахад оролцож энгийн жижиг хэргүүд, гэмт хэрэгтэн гэм буруугаа өөрөө хүлээсэн, мөн гэр бүлийн маргааныг шийдвэрлэх, батлан даалтанд авах зэрэг тухайн орон нутгийн хуулийг зөрчсөн үйлдэл, бусдын өмчийг дур мэдэн авах зэрэг хэргүүдийг шийдэж байна¹⁹. Тухайн магистратаар томилогдох хүн нь шудрага, хүндлэл хүлээхүйц зан чанартай байх бөгөөд ихэвчлэн ахмад настнуудыг сонгодог бөгөөд заавал хуулийн чиглэлийн мэргэжилтэн байхыг шаарддаггүй бөгөөд Тус хөтөлбөр эхэлснээс хойш 200 гаран магистрат үйл ажиллагаа явуулж байна.

Дүгнэлт

Гадаад улсуудын нүүдлийн шүүхийн туршлагыг харьцуулан үзэхэд ихэвчлэн хөгжил буурай, хүн амын дунд ядуурал ихтэй, боловсролын түвшин доогуур, шүүхийн хүртээмж муу эсвэл дотоодын зэвсэгт мөргөлдөөнтэй, эмх замбараагүй байдалтай улсуудад ихэвчлэн хэрэглэж байх бөгөөд онцлог гол шинжээр нь дараах байдлаар харьцуулав:

Ямар хэргийг хянан шийдвэрлэж байна вэ?

Нүүдлийн шүүх нь ихэвчлэн иргэний хэрэг, нийгмийн хор аюулын түвшингээр бага эрүүгийн хэрэг, гэр бүлийн хэрэг, өсвөр насныхан холбогдсон гэмт хэргийг хянан шийдвэрлэж байна. Мөн зарим улсад зөвхөн тодорхой төрлийн хэргийг хянан шийдвэрлэх зорилгоор нүүдлийн шүүхийг байгуулах тохиолдол байна. Жишээ нь: зөвхөн хүчингийн хэрэг гэх мэт.

Нүүдлийн шүүхүүд тусгай байр сав, уналгын хэрэгсэлтэй юу?

¹⁹ Шүүхийн шинэчлэлийн хөтөлбөр.

http://www.courts.qld.gov.au/data/assets/pdf_file/0003/205644/cip-fs-remote-jp-mag-court-program.pdf болон <http://www.courts.qld.gov.au/courts/courts-innovation-programs/community-justice-group-program>

Пакистан, Энэтхэг, Уганда зэрэг улсууд нүүдлийн шүүхийн зориулалтын автобусыг хэрэглэж байгаа бол зарим улсууд шууд олон нийтэд нээлттэйгээр гадаа шүүн таслах үйл ажиллагаа явуулж байна.

Нүүдлийн шүүх нь иргэдийн хүсэлтийн дагуу эсвэл өөрийн санаачлагаараа нүүдэллэн ажиллаж байна уу?

Харьцуулан судласан улсуудын хувьд тус улсуудын шүүх, хууль зүйн яам болон олон улсын байгууллагын санаачлагаар шүүхийн эрхэм зорилгыг хангах бодлогын хүрээнд шүүн таслах ажиллагааг олон нийтэд нээлттэй явуулах, шүүхийн ачааллыг бууруулах, эрхээ хамгаалах чадваргүй нийгмийн эмзэг бүлэг, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрхийг хамгаалах үүднээс шүүн таслах үйл ажиллагааг явуулж байна.

Нүүдлийн шүүх үр өгөөжтэй байж чадаж байна уу?

Дээрх улсуудын хувьд хямд, шуурхай шүүн таслах ажиллагааг нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд болон эрх зүйн мэдлэг, мэдээлэл, дэд бүтэц болон бусад олон шалтгаанаар эрх, ашиг сонирхлоо шударга, бие даасан шүүхээр хамгаалуулах боломж нь хязгаарлагдсан иргэдэд шүүхийг хүртээмжтэй, нээлттэй болгоход анхааран ихэвчлэн тодорхой төлөвлөгөө, хөтөлбөр, зорилтын дор гал унтраах хэлбэрээр нэг удаагийн болон хэсэг хугацааны арга хэмжээ хэлбэрээр хэрэглэж байна гэж дүгнэж болохуйц байна.

Харин өндөр хөгжилтэй улсуудын хувьд аль болох хямд шүүн таслах үйл ажиллагаанаас татгалзаж, мэргэшсэн, тогтвортой шүүхийг илүүд үзэж байна.

Зөвлөмж

Манай улсын улс төрийн орчин харьцангуй тайван, иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэг өндөр, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд дахь төлөөллийн эрх зүйн орчин хангалттай бүрэлдсэн, практикт нүүдлийн шүүхийн үүрэг, роль төдийлөн өндөр бус, цөөн тооны хэрэг, маргааныг л шийдвэрлэж байгаа зэрэг бодит байдлыг харгалзан үзэж Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх нүүдэллэн ажиллах журам боловсруулах эсэх талаараа нухацтай авч үзэх нь зүйтэй.